



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/477

Улаанбаатар хот

Г Т


Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах
журмыг шинэчлэх батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8, 36, 37 дугаар зүйлийг үндэслэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлзүйн заавар боловсруулах загвар”-ыг хоёрдугаар, “Эмнэлзүйн хөтөч боловсруулах загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай эмнэлзүйн заавар, хөтчийн жагсаалтыг гаргаж, жил бүр батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, зохицуулж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т даалгасгуй.
3. Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах, хэрэгжүүлэх, хянахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж, санхүүжүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал нарт, хамтран ажилладаг олон улсын болон хамтын ажиллагаатай байгууллагад санал тавьж, техникийн болон санхүүгийн дэмжлэг авах боломжийг судалж, шийдвэрлэхийг Төрийн захиргаа удирдлагын газарт тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 174 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081553

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11. дугаар сарын 23. өдрийн
4/47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР, ХӨТӨЧ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулахад энэхүү журмыг мөрдөж ажиллана.

1.2 Эмнэлзүйн заавар, хөтчийг шинээр боловсруулах, шинэчлэхдээ оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан, олон улсад зөвшөөрөгдсөн, шинэлэг арга, туршлага, эрүүл мэндийн технологийн үнэлгээний дүнд үндэслэн боловсруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3 Эмнэлзүйн заавар гэдэг нь аливаа өвчин эмгэгийг оношлох, эмчлэхэд ашиглах аргыг нотолгоонд суурилсан анагаах ухаанд тулгуурлан зохион байгуулалт, дэс дараалалтайгаар нарийвчлан заасан нэгдмэл мэдээлэл бүхий баримт бичиг юм.

1.4 Эмнэлзүйн хөтөч гэдэг нь үйлчлүүлэгч/өвчтөнд үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний явцад авах арга хэмжээг шат дараалан заасан, баталгаажуулан тэмдэглэх, хянах хэвлэмэл маягт юм.

1.5 Эмнэлзүйн хөтчийн ач холбогдол:

1.5.1 Үйлчлүүлэгч/өвчтөнд тусlamж, үйлчилгээний явцын талаар мэдээлэл өгөх

1.5.2 Тусlamж, үйлчилгээний тэгш байдал сайжрах,

1.5.3 Тусlamж, үйлчилгээ доголдох эрсдэл буурч, чанар тасралтгүй сайжрах,

1.5.4 Эмч, эмнэлгийн мэргэжилтний хоорондын харилцаа, ажлын уялдаа сайжрах,

1.5.5 Шинэ эмч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн баримжаа олох, ажлын байранд суралцах

1.5.6 Эмчилгээ, үйлчилгээнд урьдчилан төлөвлөсөн үр дүн гараагүй байгаа дохиог эрт мэдэх,

1.5.7 Тусlamж, үйлчилгээний чанарыг өөрөө үнэлэх, дотоодын болон хөндлөнгийн хяналт тавихад хялбар болох,

1.5.8 Тусlamж, үйлчилгээнд цахим бүртгэл нэвтрүүлэх суурь бий болох

1.6 Эмнэлзүйн заавар, хөтчийг боловсруулахдаа “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг” MNS 5140:2011 стандартын 2 дугаар хэсэг. “Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага”, 3 дугаар хэсэг. Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавих шаардлага”-ыг тус тус дагаж мөрднө.

Хоёр. Эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

2.1 Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн газар нь эмнэлзүйн заавар, хөтөч боловсруулах ажлыг ерөнхий удирдлага, арга зүйгээр хангаж, боловсруулсан төсөлд мэргэжлийн салбар зөвлөл, холбогдох байгууллага, Эрүүл мэндийн яамны газар, хэлтэсээс санал авсны дараа Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.

2.2 Эмнэлзүйн заавар, хөтчийн төслийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоодоос санаачлан боловсруулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилно.

2.3 Томилогдсон ажлын хэсгийг бүрдүүлэхдээ өвчтөний төлөөлөл, 10-аас доошгүй жил тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, эмч, сувилагч нарын төлөөлөл, холбогдох мэргэжлийн нийгэмлэг, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын төлөөлөл гэх мэт олон талын оролцоог хангана.

2.4 Эмнэлзүйн заавар, хөтчийг боловсруулахдаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас батлагдсан болон олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа заавар, стандартыг суурь болгож ашиглана.

2.5 Өвчний хэлбэр, өвчтөний биеийн байдал, эмчилгээний онцлогоос хамаарах оношилгоо, эмчилгээний зайлшгүй хийх тусламж, үйлчилгээ, гүйцэтгэх ажилбар, гардан үйлдэл, зөвлөгөөг эмнэлзүйн заавар, хөтчөд тусгана.

2.6 Оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг тодорхой нарийвчлан зааж, эм, био бэлдмэлийг олон улсын нэршлээр бичнэ.

2.7 Эмнэлзүйн заавар, хөтчөд ашигласан, ишлэл авсан материал, баримт бичгийн жагсаалтыг хавсаргана.

2.8 Эмнэлзүйн заавар, хөтчийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ-үнэлгээний дүн, олон улсад зөвшөөрөгдсөн шинэ технологи, арга туршлага нэвтэрсэн тухай бүрд нь судлан шинэчилнэ.

2.9 Эмнэлзүйн заавар, хөтчөд хэрэглэж байгаа мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо нь эрүүл мэндийн салбарын нэр томьёоны салбар зөвлөлөөр батлагаажуулсан ижил утга санаатай байна.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар сарын 23 өдрийн
A/474 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ
2. ӨМНӨХ ҮГ
3. ОРШИЛ

A. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- A.1. Онош эсвэл хамшинж
- A.2. Өвчний код (Өвчний олон улсын-10 ангилал)
- A.3. Хэрэглэгчид
- A.4. Зааврын зорилго, зорилт
- A.5. Зааварт ашигласан нэр томьёо, тодорхойлолт, эх сурвалж
- A.6. Тархвар зүйн мэдээлэл
 - A.6.1 Үндсэн ойлголт
 - A.6.2 Өвчний тавилан

Б. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ (АЛГОРИТМ)

Эрт илрүүлгийн дэс дараалал

- B.1. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээ
- B.2. Лабораторийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм
- B.3. Багажийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм
- B.4. Эмчилгээний алгоритм
- B.5. Үйлчлүүлэгчийн дараагийн шатны эмчид илгээх зарчим

В. ҮЙЛДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

- B.1. Өвчний олон улсын 10-р ангилал болон үйлдлийн олон улсын 9-р ангилал
- B.2. Эрсдэлт хүчин зүйлс
- B.3. Эрүүл мэндийн боловсрол
- B.4. Эрт илрүүлэг
 - B.4.1. Эрүүл мэндийн анхан шатны болон лавлагаа тусlamж, үйлчилгээ бүрд эрт илрүүлэг зохион байгуулах
 - B.4.2 Зорилтот бүлэг
 - B.4.3. Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө
 - B.4.4. Эрт илрүүлэг хийх арга техник
 - B.4.5 Шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан өвчтөнийг хянах аргазүй
- B.5. Эмгэг онош батлагдсан үеийн оношилгоо, эмчилгээ
 - B.5.1 Зовиур, эмнэлзүйн шинж

- B.5.2 Ерөнхий болон бодит үзлэг, багажийн шинжилгээ
- B.5.2.1 Дурдатгал (анамнез)
- B.5.2.2 Бодит үзлэг
- B.5.2.3 Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусlamж үзүүлэх шалгуур
- B.5.2.4 Лабораторийн шинжилгээ
- B.5.2.5 Багажийн шинжилгээ
- B.5.2.6 Оношилгооны шалгуур
- B.5.2.7 Ялган оношилгоо
- B.5.3 Өвчтөнг илгээх шалгуур
- B.5.4 Эмчилгээ
- B.5.4.1 Эмийн бус эмчилгээ/заалт, эмчилгээ үргэлжлэх хугацаа, хүндрэл, анхаарах заалт/
- B.5.4.2 Эмийн эмчилгээ /Эмийн нэрийг олон улсын нэршлээр бичнэ. нэгдүгээр сонголтын эм, дараагийн сонголтын эмийн тун хэмжээ, тун хоорондын зай, эмчилгээ үргэлжлэх хугацаа, анхаарах заалт, хоруу нөлөөний тухай мэдээлэл/
- B.5.4.3 Мэс засал эмчилгээ /заалт, нөхцөл, бэлтгэл, арга техник, мэс заслын өмнө, явцад болон дараа тавих хяналт/
- B.5.4.4 Хяналт
- B.5.4.5 Хяналт ба үнэлгээ

ХАВСРАЛТУУД

НОМ ЗҮЙ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11 дугаар сарын 25 өдрийн
~~4/11~~ дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ЭМНЭЛЗҮЙН ХӨТӨЧ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эмнэлзүйн хөтчийн бүрэлдэхүүн хэсэг.
 - 1.1.1 Үйлчлүүлэгч/өвчтөний иргэний бүртгэлийн мэдээлэл,
 - 1.1.2 Үйлчлүүлэгч/өвчтөнөөс зөвшөөрөл авах хэсэг,
 - 1.1.3 Өвчтөний түүх, тусlamж, үйлчилгээний хэрэгцээ (зовиур, шаналгаа),
 - 1.1.4 Үйлчлүүлэгч/ өвчтөнд үзүүлэх тусlamж, үйлчилгээний явц авах арга хэмжээний шатлал, жагсаалт,
 - 1.1.5 Горимоос гажсан тухай тэмдэглэлийн хэсэг/хэвийн үзүүлэлтийг тоочих, эсвэл дүрслэл, графикаар тэмдэглэхээр байж болно/,
 - 1.1.6 Бусад тэмдэглэгээний хэсэг,
 - 1.1.7 Тусlamж, үйлчилгээ үзүүлсэн огноо, цаг хугацааг тэмдэглэх хэсэг,
 - 1.1.8 Тусlamж, үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний гарын үсэг.
 - 1.1.9 Тусlamж, үйлчилгээ үзүүлэх явцад авах арга хэмжээг тодорхой бичнэ.
- 1.2 Эрсдэл ихтэй ажилбар, арга хэмжээ, мөн туршлага багатай эмч, эмнэлгийн мэргэжилтний түгээмэл гаргадаг алдаатай холбоотой зааварчилгааг тодорхой өгнө.

ТӨГСӨВ.